

*Г.Амарсанаа*  
*Нийслэлийн Боловсролын газрын технологи, тусгай*  
*хэрэгцээт боловсрол хариуцсан мэргэжилтэн*

Нийслэлийн ЕБС-ийн суурь боловсролын Дүрслэх урлаг, дизайн  
технологийн хичээлийн нэгдсэн хөтөлбөрийн жилийн тогтолцоог  
хэрэгжүүлэх ЕРӨНХИЙ ЗӨВЛӨМЖ

Нийслэлийн ЕБС-иудад Дүрслэх урлаг, дизайн технологийн хичээлийн нэгдсэн хөтөлбөр хэрэгжүүлэхээр Нийслэлийн дүрслэх урлаг, дизайн технологийн мэргэжлийн нийслэлийн сургагч багш, дүүрэг бүсийн ахлагч, зөвлөлдөх багийн гишүүд, зөвлөх, тэргүүлэх зэрэгтэй, олон жил ажилласан туршлагатай, ном, сурах бичигийн зохиогч, хөтөлбөрийн үндэсний багт ажиллаж байсан багш нараар хөтөлбөрийн баг бүрдүүлэн ажиллаа.

Энэхүү нийслэлийн нэгдсэн хөтөлбөрийг боловсруулах болсон зорилго нь олон жил хэрэгжүүлж, туршигдаж, тодорхой үр дүнгээ үзүүлж ирсэн тогтсон агуулгыг үндэс болгон сургалтын хэрэглэгдэхүүний шаардлага хангасан, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, материал, олдоц элбэг, боловсруулахад хялбар эдлэл, зах зээл дэх боломжийг ашиглан сурагчдын нас сэтгэхүй, орон нутгийн онцлогт түшиглэн сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй, системтэй, харилцан хамааралтай, интеграц байдлаар явуулахдаа агуулгын өргөсгөл, гүнзгийрлийг харгалзан үзсэнд оршино.

Эдгээрийг боловсруулахдаа суурь боловсролын 6-9 ангийн дүрслэх урлаг, дизайн технологи /зураг зүй, эрэгтэй, эмэгтэй технологи/ хичээлийн үндсэн суурь ухагдхуун, заавал олгох буюу нэмэлтээр болон сонголтоор орох нөхцөлийг түлхүү харгалзан анги, улирал, бүлэг болон нэгж, ээлжит хичээлээр яг ямар ойлголтыг олгох боломж буйг үндэслэн боловсрууллаа.

Үүнд дүрслэх урлаг, дизайн технологи /зураг зүй, эрэгтэй, эмэгтэй технологи/ хичээлүүдийн хэрэгжүүлж ирсэн сургалтын стандарт, киррикилюм /ай тус бүрдэх агуулга/, цөм хөтөлбөр, агуулгад баримжаалсан сургалтын хөтөлбөр зэрэг үе үеийн Боловсролын салбарын сайдын тушаал, тэдгээрийг даган гарсан тушаал, шийдвэр, зөвлөмжийг харгазан үзлээ. Мөн одоо хэрэгжүүлж байгаа сургалтын агуулга, сурах бичиг, мэргэжлийн багш нарын мэргэшлийн түвшин, сургуулиуд дахь сургалтын хэрэглэгдэхүүн, ирээдүйн чиг хандлагт илүүтэй түшиглэн ажиллаа.

Нийслэлийн дүрслэх урлаг, дизайн технологийн хичээлийн нэгдсэн хөтөлбөр боловсруулах болсон шалтгаан нь нийслэлийн төрийн болон төрийн бус өмчийн сургуулиуд тухайн жилийн батлагдсан сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан цагаар сургалтын үйл ажиллагааг явуулахгүй, багшийн өөрийн боловсруулсан сургалтын төлөвлөгөөг нарийн хянаж батлахгүй, сургууль бүр өөр өөр, агуулгийн болон судлах цагийн зөрөө их, багш бүр өөрийн мэргэшил, сонирхсон чиглэл болон чадвартаа хэт чиглэсэн зөвхөн түүндээ тулгуурлан сургалтаа явуулах, сургалтын менежерээр баталсан хөтөлбөрөөрөө явахгүй, хөндлөнгийн шалгалтаар урьдах ангид болон өмнөх цагуудад

заавал судлагдсан байх хичээл, сэдэв ороогүй байх зэрэг асуудлууд цөөнгүй гарах болсон, шийдвэр гаргах эрх бүхий газраас гаргасан хөтөлбөр, түүний зөвлөмж нь бүрхэг, салаа утгатай, эдгээрийг хянах, засварлах боломжгүй байх зэрэг нэлээд асуудал гарсаар ирсэн.

Нэгдсэн хөтөлбөрийг хэрэгжүүлснээр нэг нутаг дэвсгэрт байрлах ижил түвшний сургуулиудийн суурь боловсролын сургалтын хөтөлбөр, агуулга, мэргэжлийн багш нарын цагийн хувиарлалт, үзэх сэдэв, цаг ижил болох, хөндлөнгийн шалгалтын асуулгын зөрөөгүй байх, сургуулиудын сургалтын чанар, үйл явцыг хянах, харьцуулалт хийгдэх, өөр өөр сургуулийн суралцагчдын мэдлэгийн болон чадварын түвшин ойртох, багш нарын мэргэшүүлэх сургалт семинарыг тогтсон сэдвээр явуулах зэрэг олон үйл ажиллагаанд тодорхой үр дүнд хүрнэ гэж тооцлоо.

Мөн багшийн хувьд анги бүрт орох сургалтын төлөвлөгөөг жил бүр гаргахгүй, сэдэв, цагийн ачааллыг тооцох, ямар агуулгийг хэдийд орох, тухайн сэдвийн боловсруулалт хийхэд тодорхой, ойлгомжтой болж, зөвхөн батлуулахын тулд хийгддэг тэдгээрийн үр дүнг тооцуулахад хүнд байх зэрэг бэрхшээл, бичиг цаасны их дарамт гэж ярилцдаг зүйлээсээ ангижирна гэж бодлоо.

Энэ үйл ажиллагааг хэрэгжүүлсэнээр бусад судлагдахууны нэгдсэн хөтөлбөрүүд гарах, нийслэлийн ЕБС-ын сургалтын үйл ажиллагаа жигдрэх, цаг хугацааны хувьд ижилсэх, хяналтын тогтолцоог нягтруулах зэрэг эерэг үр дүн үзүүлнэ гэж дүгнэж байна.

Цаашлаад олон жил яригдсан үндэсний тогтсон хөтөлбөрийн эхлэл ч байж болох юм.

Багш нар тухайн агуулгыг сурагчдад хэрхэн хүргэх, мэдлэг бүтээлгэх, чадвар суулгах арга зүйгээ өөрсдөө чөлөөтэй сонгох эрхтэй.

Энэхүү сургалтын нэгдсэн хөтөлбөрийг боловсруулах гэж хагас жил баг болон ажилласан нийслэлийн сургагч, дүүрэг, бүсийн ахлагч, зөвлөх, тэргүүлэх зэрэгтэй, сэтгэлтэй, итгэлтэй, уйгүй ажилласан багш нартаа баярлалаа. /Эдгээр багш маань олон улсын жишгээр боловсролын хүрээлэнгээс нь боловсруулж өгдөг ажлыг сэтгэлээрээ хийж гүйцэтгэсэн юм./

Номын цагаан буян дэлгэрэх болтугай.

Зөвлөмжийг боловсруулсан:

НБГ-ын технологи, тусгай хэрэгцээт боловсрол хариуцсан мэргэжилтэн Г.Амарсанаа.

*Жич: Анги бүрийг дүрслэх урлаг, дизайн технологи судлагдхуунаар нь тогтолцоо хэлбэрээр цувралаар НБГ-ын [edub.edu.mn](http://edub.edu.mn) сайт Монголын зураг технологийн багш нарын холбооны нэгдсэн групп дээр байрлуулах /одоо тус групп дээр байрлуулан санал авч байна. Төсөл хэлбэрээр учир шууд ашиглах боломжгүй, хэрэглэх хугацааг зарлана./ бөгөөд та бүхэн шууд хэвлэн авч сайтар судлан танилцаж, батлуулан сургалтынхаа үйл ажиллагаанд хэрэглээрэй. Байрлуулсан тогтолцоо бүрийн дараа хэрхэн хэрэгжүүлэх үлгэрчилсэн зөвлөмжийг судлагдахуун, анги бүр дээр ажилласан багийнхан маань хүргэж*

*байх болно. Мөн тухайн хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад үүссэн бэрхшээл засан сайжруулах зөвлөмжийг хүлээн авч анхааран ажиллах болно. Мөн Боловсролын төрийн захиргааны төв байгууллага болон орон нутгийн захиргааны төв байгууллагын баталсанаас бусад сурах бичиг, ном гарын авлага нэмэлтээр ашиглах нь нээлттэй ч түүнээс гарах сөрөг үр дагаварыг тухайн байгууллага хариуцдаггүй журамтай.*